

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
НОРОВЫН АЛТАНХУЯГ, БҮГД НАЙРАМДАХ
ТУРК УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
РЭЖЭП ТАЙИП ЭРДОАН НАРЫН
ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ**

Монгол Улсын Ерөнхий сайд Эрхэмсэг ноён Норовын Алтанхуягийн урилгаар Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхий сайд Эрхэмсэг ноён Рэжэп Тайип Эрдоан 2013 оны 4 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийв.

Хоёр улсын Ерөнхий сайд нар ганцаарчилсан уулзалт хийж, өргөтгөсөн хэлэлцээ хийв. Турк Улсын Ерөнхий сайд Эрхэмсэг ноён Рэжэп Тайип Эрдоан Монгол Улсын Ерөнхийлөгч Эрхэмсэг ноён Ц.Элбэгдорж, Монгол Улсын Их Хурлын дарга Эрхэмсэг ноён З.Энхболд нарт бараалхав.

Олон зууны тэртээ нэг нутаг дэвсгэр дээр хаяа дэрлэн хамт оршин сууж, ижил төстэй хэл соёл, өв уламжлал, түүхийн хэлхээ холбоотой болсон Монгол, Туркийн ард түмний уламжлалт найрсаг харилцаа сүүлийн жилүүдэд сэргэн хөгжиж ирснийг цаашид улам идэвхжүүлж, харилцан ашигтай хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх өргөн боломж байгааг хоёр тал онцлон тэмдэглэв.

Монгол Улс Гадаад бодлогын үзэл баримтлалдаа Бүгд Найрамдах Турк Улсыг “гуравдагч хөрш”-өөр зарлан тунхагласныг туркийн тал талархан тэмдэглэв.

Хоёр тал Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 онд БНТУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр гаргасан хамтарсан мэдэгдэлд дэвшүүлсэн “иж бүрэн түншлэлийн харилцаа” нь тодорхой зорилго зарчмын хүрээнд амжилттай хэрэгжиж буйд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлээд цаашид харилцааны түвшинг ахиулж, “стратегийн түншлэлд” хүргэх хэтийн зорилготой байгаагаа талууд санал нэгтэй тэмдэглэв.

Монгол Улсын Шинэчлэлийн Засгийн газар бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаад түркийн тал баяр хүргээд, монголын талын хүсэлтийг харгалзан бололцоотой төсөл, хөтөлбөрт хамтран ажиллахад бэлэн байгаагаа мэдэгдэв.

2012 оны 7 дугаар сараас Истанбул-Улаанбаатарын чиглэлд шууд нислэг нээгдсэн нь хоёр улсын хооронд бизнес,

аялал жуулчлалыг хөгжүүлэх, иргэд харилцан зорчих явдлыг нэмэгдүүлэх, улмаар харилцаа, хамтын ажиллагааг өргөтгөхөд чухал ач холбогдолтой болохыг талууд тэмдэглээд, монголын тал цаашид уг чиглэл дэх нислэгийн тоог нэмэгдүүлэх, Монгол Улсад зорчих Туркийн иргэдийг визээс чөлөөлөх асуудлыг нааштайгаар шийдвэрлэхээ илэрхийлэв.

2013 оны 3 дугаар сарын 27-28-нд Анкара хотноо болсон Эдийн засаг, худалдааны Монгол, Туркийн Засгийн газар хоорондын хамтарсан хорооны 7 дугаар хуралдаан хоёр улсын эдийн засаг, худалдааны харилцааг тодорхой чиглэлээр идэвхжүүлэх шийдвэр гаргасныг онцлон тэмдэглэв. Тухайлбал, орон сууцны барилга, зам, гүүр барих, гэр хорооллыг дахин төлөвлөж, барилгажуулах, арьс, шир боловсруулж, бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор дэд бүтцийг сайжруулах чиглэлээр хоёр тал Засгийн газар хооронд болон хувийн хэвшлийн хүрээнд хамтран ажиллахаар тохиролцсоныг сайшаан тэмдэглэв.

Хоёр тал агаарын тээврийн салбарт харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэх сонирхлоо илэрхийлэв.

Туркийн олон улсын хамтын ажиллагааны агентлаг (ТІСА) Монгол Улсад хөгжлийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж буйд монголын тал талархал илэрхийлж, цаашид уг хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэх сонирхолтой байгаагаа онцлов.

Хоёр тал НҮБ болон бусад олон улсын байгууллагын хүрээнд идэвхтэй хамтран ажиллаж ирснийг цохон тэмдэглээд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын бус гишүүний сонгуульд бие биенээ харилцан дэмжих тохиролцоо байгуулсныг дахин нотлов.

Дээрх хамтын ажиллагааны хүрээнд ЕХРО-2020 үзэсгэлэнг “Илүү сайхан дэлхийн төлөөх шинэ арга замууд-Хүн бүр эрүүл энх” сэдвээр зохион байгуулагч орноор нэр дэвшиж буй Измир хотыг монголын тал дэмжинэ гэдэгт итгэлтэй байгаагаа туркийн тал илэрхийлэв.

Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого идэвхтэй явуулж, ЕАБХАБ-д гишүүн орон болсон, мөн 2011-2013 онд Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийг (АОХН) даргалах үүргээ нэр төртэй биелүүлж байгаад туркийн тал баяр хүргээд удахгүй Улаанбаатар хотноо болох АОХН-ийн Сайд нарын бага хурлын үйл ажиллагаанд амжилт хүсэв.

Бүгд Найрамдах Турк Улс 2020 оны зуны олимпийн наадмыг зохион байгуулахаар өрсөлдөж, бүс нутагтаа хөгжил, дэвшлийн үлгэр дууриалал болж байгаад монголын тал баяр хүргэж, амжилт

хүсэв.

Талууд БНТУ-ын Ерөнхий сайд Эрхэмсэг ноён Рэжэп Тайип Эрдоаны Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлал хоёр улсын түүхэн уламжлалт, дотно найрсаг харилцааг улам бэхжүүлэн хөгжүүлэх, хоёр талын эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаанд чухал түлхэц өгснийг санал нэгтэй тэмдэглэв.

2013 оны 4-р сарын 18